



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4 (481)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Шинжлэх ухаан, технологийн тухай
/шинэчилсэн найруулга/*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох
тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны нэгдүгээр сарын 23

№4 (481)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

48.	Шинэжлэх ухаан, технологийн тухай /шинэчилсэн найруулга/	78
49.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	88
50.	Шинэжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай	89
51.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай	89

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

52.	Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 98	89
-----	--	-----------	----

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

53.	Тогтоол хүчингүй болгох тухай	Дугаар 284	91
54.	Ажлаас чөлөөлөх, ажигд түр томилох тухай	Дугаар 286	91
55.	Журам батлах тухай	Дугаар 288	91
56.	2007 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 289	93
57.	2007 оныг "Их бүтээн байгуулалт - шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил" болгох тухай	Дугаар 290	94
58.	Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай	Дугаар 295	94
59.	Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай	Дугаар 296	94
60.	Ажигд томилох, ажлаас чөлөөлөх тухай	Дугаар 300	95
61.	Хөтөлбөр төлөвлөгөө батлах тухай	Дугаар 309	95
62.	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 12	101
63.	Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 13	101
64.	Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 14	104
65.	Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэрийн хэмжээг нэмэгдүүлэх тухай	Дугаар 15	104

2006 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Улаанбаатар
хот

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, үг үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтооходой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "технологи" гэж оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаат үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргуудын цогцыг;

3.1.2. "шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа" гэж эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шинэ болон нэмэлт мэдлэг, шинэ арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг;

3.1.3. "суурь судалгаа" гэж хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн туршилтын болон онолын үйл ажиллагааг;

3.1.4. "хавсарга судалгаа" гэж шинэ мэдлэгийг ашиглахад чиглэсэн судалгаа, туршилтын ажлыг;

3.1.5. "эрдэм шинжилгээний ажлын үр дүн" гэж шинжлэх ухааны үйл ажиллагааны хүрээнд бий болсон шинэ болон нэмэлт мэдлэг, техник технологийн шийдлийг илэрхийлсэн мэдээллийг;

3.1.6. "грант" гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсаны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг;

3.1.7. "эрдэм шинжилгээний ажилтан" гэж шинжлэх ухаан, технологийн тодорхой чиглэлээр эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэдэг мэргэшсэн судлаачийг;

3.1.8. "шинжлэх ухаан, технологийн төсөл" гэж эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг онол, арга зүйн өндөр түвшинд явуулж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүн бий болгох, түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг төлөвлөсөн баримт бичгийг;

3.1.9. "инноваци" гэж эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эцсийн бүтээгдэхүүн болгон зах зээл, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх цогц үйл ажиллагааг.

4 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зарчим

4.1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд дор дурдсан зарчмыг баримтална:

4.1.1. Үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулахгүй байх;

4.1.2. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогч нь эрдэм шинжилгээ,

туршилт, зохион бүтээх ажлын чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх арга, хэлбэрийг чөлөөтэй сонгох, хэрэгжүүлэх;

4.1.3. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үндэслэл бүхий эрсдэлийг төр болон бусад санхүүжүүлэгч этгээд хүлээн зөвшөөрөх;

4.1.4. нууцын зэрэглэлд хамаарахаас бусад эрдэм шинжилгээний ажил, түүний шалгаруулалт нь чөлөөт өрсөлдөөнд үндэслэсэн ил тод, шударга, нээлттэй байх;

4.1.5. шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд иргэд, хуулийн этгээд тэгш эрхтэй, чөлөөтэй оролцох;

4.1.6. шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа нь үр ашигтай, бүтээмжтэй байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлага

5 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо

5.1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлага нь дараахь тогтолцооноос бүрдэнэ:

5.1.1. Засгийн газар;

5.1.2. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл;

5.1.3. шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;

5.1.4. Монгол Улсын Шинжлэх ухааны академи;

5.1.5. эрдэм шинжилгээний байгууллагын өөрийн удирдлагын байгууллага.

5.2. Монгол Улсын яам шинжлэх ухаан, технологийн зөвлөлтэй байж болно.

6 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх

6.1. Засгийн газар шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай холбогдсон дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

6.1.1. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг нь зохион байгуулах;

6.1.2. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлон батлах;

6.1.3. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг батлах;

6.1.4. үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх;

6.1.5. шинжлэх ухаан, технологийн салбарт мөрдөх нийтлэг дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;

6.1.6. Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл, судалгааны ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тооцож, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.7. төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;

6.1.8. хуульд заасан бусад бүрэн эрх.

7 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэн эрх

7.1. Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/-тэй байна.

7.2. Зөвлөл нь дор дурдсан асуудлыг хэлэлцэж зөвлөмж гаргана:

7.2.1. Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн өнөөгийн түвшин, цаашдын чиг хандлага;

7.2.2. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх төрийн бодлого, тэргүүлэх чиглэл, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслүүдийн санал;

7.2.3. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа;

7.2.4. төрийн төв болон нутгийн захиргааны байгууллагын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны тайлан, захиалсан төсөл, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж байгаа байдал;

7.2.5. суурь болон хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологийн ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн асуудал;

7.2.6. шинэ технологи нэвтрүүлэх, тэргүүний технологи нутагшуулах чиглэлээр технологийн парк, инкубатор, тэргүүлэх зорилтын сүлжээ байгуулах асуудал;

7.2.7. шинжлэх ухаан, технологийн сангийн тайлан;

7.2.8. тухайн жилд улсын хэмжээгээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр;

7.2.9. яамдын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх асуудал;

7.2.10. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх асуудал;

7.2.11. төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс хэрэгжүүлж буй төслүүд, тэдгээрийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлэх үр нөлөө;

7.2.12. хэрэгжүүлж дууссан шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал;

7.2.13. үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх, хөгжүүлэх асуудал;

7.2.14. шинжлэх ухааны хөгжлийн олон улсын чиг хандлагатай уялдуулан эрдэм шинжилгээ, судалгааны шинэ чиглэлийг хөгжүүлэх асуудал;

7.3.15. эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт;

7.3.16. хуульд заасан бусад чиг үүрэг.

7.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

7.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газар, шинжлэх ухааны академи, их сургуулиуд, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн төлөөллийг оролцуулах бөгөөд орон тооны нарийн бичгийн даргатай байна.

8 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шинжлэх ухаан, технологийн талаар дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

8.1.2. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;

8.1.3. Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, суурь, хавсарга судалгааны чиглэл, санхүүжилтийг батлах;

8.1.4. төрийн захиргааны бусад төв болон орон нутгийн байгууллагаас шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;

8.1.5. шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сан, сүлжээг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;

8.1.6. улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, үр дүнд нь хянан магадлагаа хийлгэх, үнэлгээ, дүгнэлт гаргуулах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг зогсоох, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэх;

8.1.7. эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах, мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг санхүүжүүлэх;

8.1.8. эрдэм шинжилгээний байгууллагад эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх, түүний үр дүнг ашиглахад зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт хийх, олгосон хөрөнгийг эргэж төлүүлэх арга хэмжээ авах;

8.1.9. шинжлэх ухаан, технологийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх;

8.1.10. шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

8.1.11. шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журмыг батлах;

8.1.12. төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын захирал (дарга)-ын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох;

8.1.13. төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

8.1.14. эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж урамшуулах;

8.1.15. шинжлэх ухаан, технологийн салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн нэгдсэн бүртгэл хөтлөх, зохицуулах;

8.1.16. хуульд заасан бусад бүрэн эрх.

8.2. Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн асуудлаар гарсан Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн зөвлөмжийг харгалзан үзнэ.

9 дүгээр зүйл. Яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэн эрх

9.1. Яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөл нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай холбогдсон дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

9.1.1. эрхэлсэн салбарын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;

9.1.2. салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн чадавхийг хөгжүүлэх;

9.1.3. салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох;

9.1.4. салбарын хэмжээнд хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл боловсруулах, захиалах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.1.5. хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;

9.1.6. эрхэлсэн салбарын хэмжээнд шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх;

9.1.7. эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

9.1.8. салбарын эрдэм шинжилгээний байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;

9.1.9. их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах;

9.1.10. хуульд заасан бусад бүрэн эрх.

9.2. Яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах ба зөвлөлийг сайд, дэд сайдын аль нэг нь толгойлно.

10 дугаар зүйл. Шинжлэх ухааны академи

10.1. Шинжлэх ухааны академийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Монгол Улсын шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

10.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт судалгаа, шинжилгээний ажил эрхэлдэг, төрийн бус өмчийн шинжлэх ухааны академийн үйл ажиллагааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогч

11 дүгээр зүйл. Эрдэм шинжилгээний байгууллага

11.1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг хуулийн этгээдийг эрдэм шинжилгээний байгууллага гэнэ.



11.2.Эрдэм шинжилгээний байгууллагыг дор дурдсан хэлбэрээр байгуулж болно:

11.2.1.хүрээлэн, төв, лаборатори, зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз;

11.2.2.эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага;

11.2.3.шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл;

11.2.4.үндэсний хэмжээний музей, номын сан.

11.3.Эрдэм шинжилгээний байгууллага нь өөрийн эрхэлсэн салбарын эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулсан судалгаа, шинжилгээний ажлын чиглэл болон хэрэгжүүлж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна.

11.4.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол эрдэм шинжилгээний байгууллага нь зохион байгуулалтын бүтцээ өөрөө тогтооно.

11.5.Энэ хуулийн 11.2.1-д заасан байгууллага нь үндсэн үйл ажиллагааныхаа чиглэлээр мэргэжлийн зэрэг ахиулах түр сургалт явуулах, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг нийтэд мэдээлэх, сурталчлах, эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах эрхтэй.

11.6.Дээд боловсролын байгууллагыг энэ хуулийн 11.2.2-т заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

11.7.Энэ хуулийн 11.2.2-т заасан байгууллага бүтэцдээ эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лаборатори, зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз байгуулан ажиллуулах эрхтэй.

11.8.Энэ хуулийн 11.2.3-т заасан байгууллага нь эрдэм шинжилгээ, туршилт, зохион

бүтээх болон аж ахуйн үйл ажиллагааг хослон явуулах эрхтэй.

11.9.Энэ хуулийн 11.2.3-т заасан байгууллагын үйл ажиллагааг хэд хэдэн хуулийн этгээд гэрээний үндсэн дээр, эсхүл Иргэний хуулийн 25.4-т заасны дагуу хуулийн этгээдийн нэгдлийн хэлбэрээр эрхлэн гүйцэтгэж болох бөгөөд удирдлага, зохион байгуулалт, оролцогчдын эрх, үүргийг үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.

11.10.Энэ хуулийн 11.2.3-т заасан байгууллагын эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажилтай холбогдсон харилцааг энэ хуулиар, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

11.11.Энэ хуулийн 11.2.3-т заасан байгууллагын үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батлах бөгөөд удирдлагыг нь Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

11.12.Энэ хуулийн 11.2.4-т заасан байгууллага нь өөрийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дангаараа буюу эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд тэдгээрийг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

11.13.Эрдэм шинжилгээний байгууллага нь өөрийн нэр, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, харилцах данстай байх ба бэлгэ тэмдэг хэрэглэж болно.

11.14.Эрдэм шинжилгээний байгууллага нь зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон туршилт явуулах бусад нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд ийнхүү хангах үүргийг үүсгэн байгуулагч хүлээнэ.

12 дугаар зүйл. Эрдэм шинжилгээний байгууллагыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах

12.1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол дор дурдсан этгээд эрдэм шинжилгээний байгууллагыг үүсгэн байгуулах эрхтэй:

12.1.1.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой эрдэм шинжилгээний байгууллагыг Засгийн газар;

12.1.2.төрийн бус өмчийн эрдэм шинжилгээний байгууллагыг холбогдох хуульд заасан журмын дагуу үүсгэн байгуулагч нь.

12.2.Эрдэм шинжилгээний байгууллагыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгэнэ.

12.3.Эрдэм шинжилгээний байгууллагыг өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ асуудлыг үүсгэн байгуулагч нь шийдвэрлэнэ.

12.4.Эрдэм шинжилгээний байгууллагыг Иргэний хуулийн 32.1-д заасан үндэслэлээр татан буулгана.

12.5.Энэ хуулийн 12.1.1-д заасан байгууллагад төрийн өмчийн төлөөлөл ажиллуулах, төрийн өмчийн эзэмшил, ашиглалт, зарцуулалтад хяналт тавихтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулна.

13 дугаар зүйл. Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтны нийтлэг эрх, үүрэг

13.1.Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:

13.1.1.суурь, хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологийн төслийг гүйцэтгэх шалгаруулалтад оролцох;

13.1.2.хууль тогтоомжоор нууцад хамааруулснаас бусад мэдээллийг чөлөөтэй олж авах;

13.1.3.хууль тогтоомжоор төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлынхаа үр дүнг олон нийтэд мэдээлэх;

13.1.4.шинжлэх ухаан, технологийн чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагаас зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, чуулганд оролцох, судалгааныхаа ажлын үр дүнг мэдээлэх, харилцан мэдээлэл солилцох;

13.1.5.олон улсын болон дотоод, гадаадын шинжлэх ухааны байгууллага, нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх, тэдгээрийн удирдлагад сонгогдох;

13.1.6.эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх нөхцөл бололцоогоор хангагдах;

13.1.7.эрдэм шинжилгээний ажил болон бүтээлээ бодитойгоор үнэлүүлж, тохирсон шагнал, урамшуулал хүртэх, хуульд заасан хөнгөлөлт эдлэх;

13.1.8.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг харилцан солилцох, хэвлэн нийтлэх;

13.1.9.эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл өгөх.

13.2.Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:

13.2.1.шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зарчим, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй, нэр төрийг эрхэмлэн ажиллах;

13.2.2.шинжлэх ухаан, технологийн төсөл, туршилт, грантыг бодитой хэрэгжүүлэх;

13.2.3.үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх бол байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх;

13.2.4.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг уг ажлыг дууссанаас хойш 60 хоногт багтаан шинжлэх ухаан, технологийн мэдээллийн санд хүргүүлж хадгалуулах;

13.2.5.эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, түүнчлэн санхүүжилтийн зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын шаардсанаар тухай бүр үнэн зөв гаргаж өгөх;

13.2.6.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц буюу үр дүнд байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхээр байдал илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэж дүгнэлт гаргуулах, уг



байдал тогтоогдвол ажлаа зогсоох, учирч болох сөрөг нөлөөлөл, хохирлын талаар захиалагч, санхүүжүүлэгч, холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;

13.2.7. шинжлэх ухаан, технологийн салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн тухай мэдээллийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх;

13.2.8. эрдэм шинжилгээний нь ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглахад хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилт

14 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр

14.1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

14.1.1. улсын төсвөөс олгосон хөрөнгө;

14.1.2. орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө;

14.1.3. гадаад улс, олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө;

14.1.4. гадаад улсын болон Монгол Улсын иргэн, байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж;

14.1.5. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

15 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх журам

15.1. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг дараахь журмаар санхүүжүүлнэ:

15.1.1. Засгийн газрын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр;

15.1.2. нутгийн захиргааны байгууллагын захиалгатай эрдэм шинжилгээ,

туршилт, зохион бүтээх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр;

15.1.3. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагчийн хөрөнгөөр.

15.2. Энэ хуулийн 15.1.1-д заасны дагуу санхүүжилт хийхдээ шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд хамаарах суурь судалгаа, төслийг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ.

15.3. Энэ хуулийн 15.1.2, 15.1.3-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил нь Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын хөгжлийг түргэтгэх, үр ашигтай шинэ салбарыг үүсгэн хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, экспортын нөөцийг өсгөх болон импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчээр хангах, байгаль орчныг хамгаалах зэрэг стратегийн асуудлыг судлан шийдвэрлэхэд чиглэгдэж байгаа бол уг ажлын тодорхой хэсгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж болно.

16 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох журам

16.1. Энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу хянан магадлагаа хийж шалгаруулна.

16.2. Энэ хуулийн 16.1-д зааснаар шалгарсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг санхүүжүүлэхэд олгох хөрөнгийн хэмжээг Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

16.3. Энэ хуулийн 16.1-д заасан ажлын захиалагч нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд тэдгээр нь Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэгчтэй төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ байгуулна.

16.4. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага үйл ажиллагааныхаа үндсэн

чиглэлийн дагуу суурь, хавсарга судалгааг гүйцэтгэх бол тэдгээрт грант олгох, эсхүл уг байгууллагад санхүүжилт олгох замаар асуудлыг зохицуулж болно.

16.5. Энэ хуулийн 15.1.3-д заасны дагуу 14.1.3-14.1.5-д заасан эх үүсвэрээс гүйцэтгэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу санхүүжүүлнэ.

16.6. Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын барилга байгууламж, сорилт, туршилтын зориулалттай тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахтай холбогдсон зардлыг улсын төсөвт тусгах, санхүүжүүлэх асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

17 дугаар зүйл. Захиалагчийн эрх, үүрэг

17.1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын захиалагч дор дурдсан эрх эдэлнэ:

17.1.1. санхүүжилтийн зориулалтаар олгогдох хөрөнгийн талаар саналаа шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;

17.1.2. гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон хөдлөх, үл хөдлөх болон эдийн бус хөрөнгийг өмчлөх;

17.1.3. ажлын явц, гүйцэтгэл, санхүүжилтийн тайлан, мэдээг гүйцэтгэгчээс гаргуулж авах;

17.1.4. төслийн санхүүжилтэд аудит хийлгэж дүгнэлт гаргуулах;

17.1.5. төслийн гүйцэтгэл гэрээнд заасан шаардлага хангаагүй бол олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;

17.1.6. захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах асуудлыг гүйцэтгэгчтэй хамтран шийдвэрлэх;

17.1.7. төслийн гүйцэтгэлтэй холбогдсон маргааныг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

17.1.8. хууль, гэрээнд заасан бусад эрх.

17.2. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын захиалагч дор дурдсан үүрэгтэй:

17.2.1. захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжүүлэгчтэй гэрээ байгуулах;

17.2.2. санхүүжүүлэгчээс олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;

17.2.3. гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч хянан, баталгаажуулах арга хэмжээг уг ажлын үр дүнг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх;

17.2.4. захиалсан ажлынхаа санхүүжилтийн сар, улирлын хуваарийг санхүүжүүлэгчтэй хамтран тодорхойлох;

17.2.5. Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр төсөл хэрэгжүүлсэн бол үр дүнг нь үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж ашигласны эхний 3 жилийн дундаж ашгийн 15 хувийг Санд шилжүүлэх;

17.2.6. Шинжлэх ухаан, технологийн сантай хамтарсан төсөл хэрэгжүүлэх бол уг төсөлд оруулах өөрийн хөрөнгийг Санд байршуулж зарцуулах.

17.3. Гэрээнд өөрөөр заагаагүй бол захиалагч нь гүйцэтгүүлсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж ашигласны эхний 3 жилийн дундаж ашгийн 15 хувьтай тэнцэх урамшууллыг гүйцэтгэгчид нэг удаа олгож болно.

17.4. Төрийн төв болон нутгийн захиргааны байгууллага өөрсдийн захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг гүйцэтгэгчээс хүлээн авснаас хойш 2 жилд багтаан үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд энэ тухай Зөвлөлд тайлагнана.

17.5. Төрийн төв болон нутгийн захиргааны байгууллага өөрсдийн захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг энэ хуулийн 17.4-т заасан хугацаанд болон эсхүл үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах арга хэмжээ авах боломжгүй бол энэ тухай үндэслэлээ Үндэсний зөвлөлд тайлагнах үүрэгтэй.



18 дугаар зүйл. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

18.1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч дор дурдсан эрх эдэлж үүрэг хүлээнэ:

18.1.1. гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зардал төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдэхээр байвал энэ тухай саналаа захиалагчид тавьж шийдвэрлүүлэх;

18.1.2. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхийг захиалагчаас шаардах;

18.1.3. захиалагч үүргээ биелүүлээгүй бол гэрээг цуцлах санал тавьж шийдвэрлүүлэх;

18.1.4. гэрээнд заасан бол гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлынхаа үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглуулсны эхний 3 жилийн дундаж ашгийн 15 хүртэл хувьтай тэнцэх урамшууллыг захиалагчаас шаардах;

18.1.5. гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх, хөрөнгө зардлыг оновчтой хуваарилж, үр ашигтай зарцуулах, үр дүнг тоо, чанарын хувьд захиалсан түвшингээс нь бууруулахгүйгээр боловсруулж захиалагчид хүлээлгэн өгөх;

18.1.6. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад гэрээнд заасан үр дүнд хүрэх бололцоогүй нь нотлогдсон, эсхүл давагдашгүй хүчин зүйл, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас уг ажлыг цаашид хэрэгжүүлэх бололцоогүй болсон бол энэ тухайгаа захиалагчид даруй мэдэгдэх;

18.1.7. захиалгат ажлыг гүйцэтгээгүй буюу дутуу гүйцэтгэсэн, эсхүл үр дүн нь гэрээнд заасан шаардлага хангаагүй бол доголдлыг арилгах, чанарын зохих түвшинд хүргэх ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх, эсхүл олгосон хөрөнгийг нөхөн төлөх;

18.1.8. гадаад, дотоодын байгууллага, хуулийн этгээд иргэний хөрөнгөөр гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч нь уг ажлын сэдвийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Эрдэм шинжилгээний ажилтан, түүний нийгмийн баталгаа

19 дүгээр зүйл. Эрдэм шинжилгээний ажилтан

19.1. Эрдэм шинжилгээний ажилтан нь шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь болон хавсарга судалгааны сэдэвт ажил, олон улсын судалгааны хамтарсан төсөл, хөтөлбөрт үндсэн гүйцэтгэгчээр ажиллах эрхтэй.

19.2. Эрдэм шинжилгээний ажилтанд дор дурдсан зэрэг дэв олгоно:

19.2.1. эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан;

19.2.2. эрдэм шинжилгээний ахлах ажилтан;

19.2.3. эрдэм шинжилгээний дэд ажилтан;

19.2.4. эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан.

19.3. Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.4. Судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал, үр чадварынх нь түвшин, ажлын үр дүнг үнэлэх, зэрэг дэвийг ахиулах зорилгоор эрдэм шинжилгээний ажилтныг 4 жил тутамд аттестатчилалд хамруулах бөгөөд журмыг нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20 дугаар зүйл. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй

20.1. Эрдэм шинжилгээний ажилтан нь энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан нийтлэг үүрэг болон эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн хэм хэмжээг сахин ажиллана.

20.2. Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрмийг эрдэм шинжилгээний байгууллагуудын

саналыг харгалзан шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан ёс зүйн дүрмийг зөрчсөн эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийг бууруулна.

21 дүгээр зүйл. Эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн баталгаа

21.1.Эрдэм шинжилгээний ажилтан дор дурдсан нийгмийн баталгаагаар хангагдана:

21.1.1.мэдлэг чадвар, ажлынхаа үр дүнд тохирсон цалин, нэмэгдэл хөлс, зэрэг дэв, цол, үр чадварын нэмэгдэл, нөхөх олговор, тусламж, шагнал урамшуулал авах, хуульд заасан бусад хөнгөлөлт эдлэх;

21.1.2.орон сууц барих буюу худалдан авах зориулалтаар буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл авах;

21.1.3.энэ хуулийн 11.2-т заасан байгууллагад тасралтгүй 25 ба түүнээс дээш жил эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил эрхэлсэн эрдэм шинжилгээний болон инженер-техникийн ажилтан, лаборант өндөр насны тэтгэвэр тогтоологдох бол ажиллаж байгаа байгууллагаас нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгох;

21.1.4.иргэн, хуулийн этгээд, нутгийн захиргааны байгууллагын захиалгаар эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэсэн бол захиалагчаас нэмэгдэл цалин, урамшил, бусад дэмжлэг авах;

21.1.5. хуульд заасан бусад баталгаа.

21.2.Улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагын ажилтны цалингийн сүлжээ, тэдгээрт нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

22 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал

22.1.Шинжлэх ухаан, технологийн салбарт дор дурдсан шагнал олгоно:

22.1.1.суурь, хавсарга судалгаа эрхэлж байгаль, нийгмийн шинэ үзэгдэл, хуулийг тодорхойлж, шинжлэх ухааны нээлт хийсэн иргэн, судлаачдын хамтлагт "байгаль, нийгмийн ухааны шагнал";

22.1.2.өндөр үр ашиг, ач холбогдол бүхий шинэ технологи, бүтээгдэхүүн, материал бий болгон үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж ашигласан байгууллага, иргэнд "технологийн дэвшлийн шагнал";

22.1.3.Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гадаадын иргэн, байгууллагад "шинжлэх ухаан, технологийн олон улсын хамтын ажиллагааны шагнал".

22.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам, шагналын хэмжээг Монгол Улсын Засгийн газар батална.

23 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагаа

23.1.Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын байгууллага, гадаад улс, тэдгээрийн байгууллага, хуулийн этгээд, иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэх, хамтарсан эрдэм шинжилгээний байгууллага байгуулах эрхтэй.

23.2.Гадаад улс, олон улсын байгууллагаас Монгол Улсад олгосон зээл, тусламжийн 1-ээс доошгүй хувийг эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, эрдэм шинжилгээний ажлын сорилт, туршилтын баазыг бэхжүүлэхэд зарцуулна.

23.3.Монгол Улсын харьяат эрдэмтэн, түүнчлэн эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн нь гадаад улс болон олон улсын шинжлэх ухааны нийгэмлэг, холбоо, сүлжээнд гишүүнээр элсэх эрхтэй.



24 дүгээр зүйл. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, маргааныг хянан шийдвэрлэх

24.1.Шинжлэх ухаан, технологийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавина.

24.2.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж буй шинжлэх ухаан, технологийн төслийн талаархи өргөдөл, гомдлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж шийдвэрлүүлнэ.

24.3.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж буй шинжлэх ухаан, технологийн төслийн талаар захиалагч, санхүүжүүлэгч, гүйцэтгэгчийн хооронд гарсан маргааныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

25 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

25.1.Шинжлэх ухаан, технологийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

25.1.1.энэ хуулийн 13.2.4, 13.2.5-д заасныг зөрчсөн байгууллага, хуулийн этгээдийг 100000-150000 төгрөгөөр, эрдэм шинжилгээний ажилтныг 25000-40000 төгрөгөөр торгох;

25.1.2.хүн, мал, амьтан, байгаль орчинд хортой судалгаа явуулсан, түүнчлэн энэ

хуулийн 13.2.6-д заасан үүргээ биелүүлээгүй байгууллагыг 200000-250000 төгрөгөөр, эрдэм шинжилгээний ажилтныг 40000-60000 төгрөгөөр торгох;

25.1.3.энэ хуулийн 17.2.3-т заасан үүргээ биелүүлээгүй захиалагч байгууллага, хуулийн этгээдийг 100000-150000 төгрөгөөр, албан тушаалтныг 20000-30000 төгрөгөөр торгох;

25.1.4.энэ хуулийн 17.4, 17.5-д заасан үүргээ биелүүлээгүй захиалагч байгууллага, хуулийн этгээдийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгох;

25.1.5.энэ хуулийн 17.2-т заасан үүргээ биелүүлээгүй буюу биелүүлэхээс зайлсхийсэн байгууллагыг 100000-150000 төгрөгөөр, эрдэм шинжилгээний ажилтныг 25000-40000 төгрөгөөр торгох;

25.1.6.энэ хуулийн 18.1.8-д заасан үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч байгууллагыг 200000-250000 төгрөгөөр, эрдэм шинжилгээний ажилтныг 40000-60000 төгрөгөөр торгох.

25.2.Шинжлэх ухаан, технологийн арга хэмжээнд зориулан улсын төсвөөс олгосон хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, ашигласан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг холбогдох хуулиар зохицуулна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын Их Хурлаас 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан 1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Шинжлэх ухаан технологийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 2 дахь хэсэг нэмсүгэй:

"2. Академи шинжлэх ухааны тодорхой салбараар төрөлжсөн академийг өөрийн бүтцэд байгуулж болно."

1 дэх хэсгийн "Академи" гэсний өмнө "1." гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Шинжлэх ухаан, технологийн тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц. НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт дараахь заалт нэмсүгэй:

"13.1.15. Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын туршилтын бүтээгдэхүүн."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц. НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 98

Улаанбаатар хот

Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай

Батлан хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай Улсын Их Хурлын 1998 оны 56 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого"-ыг хэвсрэлтаар баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц. НЯМДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2007 оны 98 дугаар тогтоолын хэвсрэлт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогын энэхүү баримт бичиг нь орон нутгийн хамгаалалтын үндэс, зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл, удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлно.

1.2. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогын эрхэм зорилго нь төрийн батлан хамгаалах бодлого, үйл

ажиллагааны хүрээнд улс орны, түүний дотор орон нутгийн тогтвортой хөгжлийн таатай нөхцөлийг бүрдүүлэх замаар Монгол Улсын батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлэхэд оршино.

1.3. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого нь Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалах тухай хууль, Төрийн цэргийн бодлогын үндэс болон холбогдох бусад хууль тогтоомжид үндэслэнэ.



1.4. Энэхүү баримт бичгийн үзэл санааг улсын болон орон нутгийн аюулгүй байдлыг хангах бүсчилсэн хөгжлийн бодлого, үйл ажиллагаанд тусгаж хэрэгжүүлнэ.

1.5. Орон нутгийн хамгаалалтын бодлогыг хэрэгжүүлснээр үндэсний аюулгүй байдлыг хангах, Монгол Улсын өөрийгөө хамгаалах чадавхийг бэхжүүлэх, батлан хамгаалах асуудлаар иргэн-цэргийн харилцааг төлөвшүүлэх боломж нэмэгдэнэ.

Хоёр. Орон нутгийн хамгаалалтын үндэс

2.1. Орон нутгийн хамгаалалт нь Монгол Улсын батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс, өөрийгөө хамгаалах стратеги бөгөөд орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой, бие даасан хөгжлийг дэмжих, учирч болзошгүй уламжлалт болон уламжлалт бус аюулаас урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах талаар төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагаас авч хэрэгжүүлэх олон талт арга хэмжээний цогц мөн.

2.2. Орон нутгийн хамгаалалтын зорилго нь Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлогод нийцүүлэн орон нутгийн өөрийгөө хамгаалах нийгэм, эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлэх замаар батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны цогц байдлыг хангахад оршино.

2.3. Орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалт, бодлого, үйл ажиллагаа нь урьдчилан сэргийлэх, бүтээн байгуулах чиг хандлагатай байна.

2.4. Үндэсний язгуур ашиг сонирхлыг эрхэмлэн дээдэлж, иргэний ардчилсан нийгмийн харилцааг төгөлдөржүүлэх, эх оронч үзэл, хүмүүжлийг иргэдэд төлөвшүүлэх, олон нийтийн зүгээс төрдөө дэмжлэг үзүүлэх нь Монгол Улсын өөрийгөө хамгаалах чадавхийг нэмэгдүүлэх, орон нутгийн хамгаалалтыг бэхжүүлэх чухал нөхцөл болно.

2.5. Орон нутгийн хамгаалалт нь төрийн бүх шатны байгууллагын хамтын ажиллагаа, нийт иргэдийн дэмжлэг, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын оролцоо, орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөөц бололцоонд тулгуурлана.

Гурав. Орон нутгийн хамгаалалтын зарчим

3.1. Орон нутгийн хамгаалалтыг дараахь зарчмуудад тулгуурлан хэрэгжүүлнэ:

3.1.1. төрийн удирдлага, хяналтад байх;

3.1.2. үйл ажиллагаа нь харьцангуй бие даасан, уян хатан, шуурхай байх;

3.1.3. үндсэн зорилгоо биелүүлэхэд бэлэн байх;

3.1.4. бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдсан байх;

3.1.5. үйл ажиллагаа нь ил тод байх.

Дөрөв. Орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.1. Орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагаа нь дараахь үндсэн чиглэлтэй байна:

4.1.1. орон нутгийн хамгаалалтын талаархи бодлогыг хэрэгжүүлэх;

4.1.2. аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн сүлжээг орон нутагт бий болгож хөгжүүлэх;

4.1.3. иргэдэд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх;

4.1.4. иргэдийн эрүүл мэнд, боловсролыг дээшлүүлэх.

4.2. Орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагааг тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын дараахь үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлнэ:

4.2.1. нийгмийн тогтвортой байдал, иргэдийн амгалан тайван аж төрөх нөхцөлийг хангах;

4.2.2. терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх;

4.2.3. гамшгаас хамгаалах үйл ажиллагаа;

4.2.4. орон нутгийн бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх;

4.2.5. ерөнхий зориулалтын, хилийн болон дотоодын цэргийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.2.6. дайчилгааны бэлтгэл нөөцийн болон орон нутгийн хамгаалалтанд оролцох бүрэлдэхүүнийг сургах;

4.2.7. улсын дайчилгаа, зэвсэгт хүчний дэлгэн байгуулалтад дэмжлэг үзүүлэх;

4.2.8. улсын дайчилгааны даалгавартай материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Тав. Орон нутгийн хамгаалалтын удирдлага, зохион байгуулалт

5.1. Улс орны батлан хамгаалах асуудлаар орон нутгийн удирдлагын хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэн, үйл ажиллагааны бие даасан байдлыг зохих түвшинд хангах замаар орон нутгийн хамгаалалтыг батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс болгон хөгжүүлэхэд орон нутгийн хамгаалалтын талаархи төрийн бодлого, үйл ажиллагаа чиглэгдэнэ.

5.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар нь орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж бэхжүүлэх талаархи улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн бодлогыг тус тусынхаа бүрэн эрхийн хүрээнд тодорхойлж, ерөнхий удирдлагаар хангана.

5.3. Орон нутгийн хамгаалалтын удирдлага зохион байгуулалтын үндэс, орон нутгийн хамгаалалтад төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, иргэдийн хүлээх үүрэг, эрх хэмжээг хуулиар тогтооно.

5.4. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих чиг үүргийг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

5.5. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж, бүсчилсэн хөгжлийн үйл явц

үр дүнтэй уялдуулах үүргийг Засгийн газар хариуцна.

5.6. Орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалтын үндсэн нэгж нь аймаг, нийслэл байна.

5.7. Дайны болон онц байдлын үеийн орон нутгийн хамгаалалтыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

5.8. Орон нутгийн хамгаалалтын бодлогын хэрэгжилтийн талаар жил бүр Засгийн газар Улсын Их Хуралд мэдээлнэ.

Зургаа. Бусад зүйл

6.1. Орон нутгийн хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг улсын болон орон нутгийн төсөвт тусгана.

6.2. Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлогод аюулгүй байдлын гадаад, дотоод орчинд гарч буй өөрчлөлттэй уялдуулан тодотгол хийнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр

Дугаар 284

Улаанбаатар хот

Газрын тухай хуулийн 19.1.11-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Дүрэм батлах тухай" Засгийн газрын 2003 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 117 дугаар

Тогтоол хүчингүй болгох тухай

тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
САЙД

Ж.НАРАНЦАЦРАЛТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 1-ний өдөр

Дугаар 286

Улаанбаатар хот

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өөрийнх нь гаргасан хүсэлтийн дагуу Дэлэгийн Загджавыг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Ажлаас чөлөөлөх, ажилд түр томилох тухай

2. Цэрэндуламын Шийрэвдамбыг Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Дугаар 288

Улаанбаатар хот

Харилцаа холбооны тухай хуулийн 5.1.3, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 29.1.1-ийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Журам батлах тухай

1. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль батлагдсантай холбогдуулан зөйлшгүй шаардлагатай харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутаг болон үйлчилгээ хүрээгүй



хүн амд хүргэх, шинээр сүлжээ байгуулах, өргөтгөх, шинэчлэх зорилгоор бүрдүүлэн шуудан болон цахилгаан холбооны "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Харилцаа холбооны зохицуулах хороо /Б.БОЛДБААТАР/-нд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 178 дугаар тогтоолыг хүчингүй болгонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНГИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** **С.БАТБОЛД**

Засгийн газрын 2006 оны 288 дугаар
тогтоолын хавсралт

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮҮРГИЙН САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь төрийн бодлогын хүрээнд зайлшгүй шаардлагатай мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх үүргийг хэрэгжүүлүүдлэхээр Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан /цаашид "сан" гэх/-д хөрөнгө төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Мэдээлэл харилцаа холбооны талаар төрөөс баримтлах бодлого, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх судалгааг үндэслэн тухайн жилд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, зардлын төсвийг Харилцаа холбооны зохицуулах хорооны санал болгосноор Ерөнхий сайд батална.

1.3. Алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд хүргэх зайлшгүй шаардлагатай мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээг улсын эдийн засгийн байдал, техник технологийн дэвшлийг харгалзан Харилцаа холбооны зохицуулах хорооноос жил бүр шимэчлэн тогтоож байна.

1.4. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг хуваарилах үйл ажиллагаанд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, үйлчилгээ эрхлэгчдийг ялгаварлахгүй, тэгш эрхтэйгээр оролцуулах, ил тод байх зарчмыг баримтална.

1.5. Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 22 дугаар зүйлд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

Хоёр. Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Харилцаа, холбооны зохицуулах хороо хариуцна.

2.2. Харилцаа холбооны зохицуулах хороо нь сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний талаар жилд 2 удаа Ерөнхий сайдад мэдээлж байна.

2.3. Мэдээллийн технологи, цахилгаан холбоо, шуудан болон радио телевизийн чиглэлээр үйлчилгээ эрхлэгчдийн төлөөлөөс бүрдсэн орон тооны бус Хяналтын зөвлөл сангийн үйл ажиллагаанд хяналт тавина.

2.4. Хяналтын зөвлөлийн ажиллах дүрэм, журмыг Харилцаа холбооны зохицуулах хороо батална.

Гурав. Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх, үүрэг

3.1. Харилцаа холбооны зохицуулах хороо нь холбогдох хууль болон энэхүү журмын хүрээнд дараахь эрх, үүрэгтэй байна:

3.1.1. Батлагдсан төлөвлөгөөний дагуу сангийн хөрөнгийг хуваарилах;

3.1.2. Сангийн үйл ажиллагааны зардлын төсвийг боловсруулах;

3.1.3. Бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн дүнг хянаж шийдвэрлэх;

3.1.4. Сангийн санхүүгийн тайланг гаргаж, түүнд аудит хийлгэх, улирал бүрийн тайланг авч хэлэлцэх;

3.1.5. Сангаас хуваарилсан хөрөнгийн зарцуулалт, бүх нийтийн үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэгчийн сүлжээний найдвартай ажиллагаа, үйлчилгээний чанарыг эрх бүхий байгууллагаар шалгуулах, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй гэж үзвэл хуваарилсан хөрөнгийг буцаан авах;

3.1.6. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын биелэлтийг жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулах;

3.1.7. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаархи мэдээллийг нийтад мэдээлэх.



Доров. Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах

4.1 Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7.2, 22.1, 22.2-т заасны дагуу бүрдүүлнэ.

4.2. Шуудангийн хуулийн 7.1.1-д заасан давуу эрхийн бүсэд шуудангийн үйлчилгээ эрхлэгчдээс энэхүү журмын 4.1-д зааснаас гадна Шуудангийн тухай хуулийн 9.1.2-т заасны дагуу хөрөнгө төвлөрүүлнэ.

4.3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд санд хөрөнгө төвлөрүүлэхдээ албан татвар ногдуулах орлогоо үнэн зөв тодорхойлж энэ журмын 4.1-д заасан хэмжээний хөрөнгийг сангийн дансанд төвлөрүүлнэ.

4.4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээд нь албан татвар ногдуулах орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийн тайлангаа хууль тогтоомж, дүрэм, журамд заасан хугацаанд гаргаж Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлнэ.

4.5. Энэхүү журмын 4.4-т заасан тайлангийн маягтыг Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга батална.

4.6. Сангийн хөрөнгөөр алслагдсан бүс нутагт сүлжээ барьж байгуулах болон өргөтгөх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримтална.

Тав. Сангийн хөрөнгийн зарцуулалтыг тайлагнах, хяналт тавих

5.1. Харилцаа холбооны зохицуулах хороо сангийн санхүүгийн тайланг Нэгдсэн төсвийн тухай хуульд заасан хугацаанд төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, сангийн зарцуулалтыг Засгийн газарт тайлагнана.

5.2. Санд төвлөрүүлсэн хөрөнгийн талаархи мэдээллийг үнэн зөв тодорхойлж, тайланг дараа жилийн 2 дугаар сарын 10-ны дотор холбогдох татварын албанд хүргүүлнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. Сангийн хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлсэн, хуульд зааснаас өөр зориулалтаар ашиглаж, зарцуулсан этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 289

Улаанбаатар хот

2007 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйлд заасны дагуу улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2007 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийг 2007 оны 2 дугаар сарын 15-ны дотор бэлэн болгож, барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэгчийг 5 дугаар сарын 1-ний дотор сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлсэн байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

2. 2007 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгагдсан зарим төсөл, арга хэмжээ, их засварын ажлын дэлгэрэнгүй жагсаалтыг төсвийн ерөнхийлөн захирагчдын

саналыг үндэслэн 2007 оны 1 дүгээр сарын 1-ний дотор батлан хэрэгжүүлэхийг Сангийн сайд Н.Баяртсайханд тоног төхөөрөмжийн дэлгэрэнгүй жагсаалтыг батлан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.

3. Энэ тогтоолын 1, 2 дугаар зүйлд тусгагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгох сонгон шалгаруулалт болон ажлын гүйцэтгэл, явцын талаархи мэдээллийг улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гарган Засгийн газарт танилцуулж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболд нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

Н.БАЯРТСАЙХАН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Орон даяар 2007 оныг "Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил" болгон зарласугай.

2. "Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил"-ийн хүрээнд хийж байгаа ажлын явц, үр дүнг нэгтгэн улирал тутам Засгийн газарт

2007 оныг "Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил" болгох тухай

танилцуулж байхыг Сангийн сайд Н.Баяртсайхан, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 295

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай санаачилгыг дэмжих тухай" Засгийн газрын 2006 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор баталсан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай" санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг "Гишүүд" гэсэн хэсэгт дараахь нэмэлт оруулсугай:

"-Эрдэнэт үйлдвэрийн ерөнхий захирал;

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай

-Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал /тохиролцсоноор/;

-Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн /тохиролцсоноор/;

-Ил тод байдал сангийн тэргүүн /тохиролцсоноор/.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дугаар 296

Улаанбаатар хот

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 15.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Химийн хорт болон аюултай бодисыг Монгол Улсын улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалтыг дор дурдсанаар баталсугай:

а/Дорноговь аймаг дахь Замын-Үүдийн

боомт;

б/Сэлэнгэ аймаг дахь Алтанбулагийн

боомт;

в/Сэлэнгэ аймаг дахь Сүхбаатар боомт;
г/Чингис хаан олон улсын нисэх буудлын

хилийн шалган нэвтрүүлэх боомт.

Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэх боомтын жагсаалт батлах тухай

2. Химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Монгол Улсын сайд У.Хүрэлсүх, Улсын гаалийн ерөнхий газрын дарга Б.Баттөмөр нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 300

Улаанбаатар хот

Ажилд томилох, ажлаас чөлөөлөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 18¹ дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Азадын Баатарцогтыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Хил хамгаалах ерөнхий газрын даргаар томилсугай.

2. Өөр ажилд шилжсэн тул Паламын Сүндэвийг Засгийн газрын тохируулагч агентлаг-

Хил хамгаалах ерөнхий газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**
ДОДБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 12 дугаар сарын 20-ны өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Улсын Их Хурлын 2006 оны 74 дүгээр тогтоолын 1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, үг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дээрх хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**
М.ЭНХБОЛД
**БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД**
И.ЭРДЭНЭБААТАР
Засгийн газрын 2006 оны 309 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БАЙГАЛЬ ОРЧИНД СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ХОХИРОЛ БАГАТАЙ ЯВУУЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг, Нийтлэг үндэслэл

Уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх талаар төр, засгаас хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, шийдвэрүүд хэрэгжсэний үр дүнд уул уурхайн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн үндэсний нийт бүтээгдэхүүний 20.3 хувь, экспортын бүтээгдэхүүний 73.8 хувийг эзлэх боллоо. Гэвч ухаж эвдсэн газар, газрын хэвлийг нөхөн сэргээх талаар төрийн бодлогын хүрээнд өргөн цар хүрээтэй, дорвитой арга хэмжээ аваагүй байна.

1990 оноос хойш алтны шороон ордыг ашигласнаас 500-гаад сая шоо метр газрын хэвлий эвдэж, хаягдал овоолго үүсгэсэн байна. Үүний улмаас манай улсын газар нутгийн унаган төрх алдагдаж, мал аж ахуй, газар тариалангийн үйл ажиллагаанд бэрхшээл гарч, олон арван гол горхи ширгэж, гол мөрний усны түвшин багасч, байгаль орчин, экологид их хэмжээний хохирол учирсан байна. Иймээс ашигт малтмал ашиглах үйл

ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай явуулах шаардлага урган гарч байна.

Хоёр, Хөтөлбөрийн зорилго, зорилт

Хөтөлбөрийн зорилго нь ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг байгаль орчинд сөрөг нөлөөлөл, хохирол багатай, ээлтэй технологиор явуулах, ашигт малтмалын орд газрын нөхөн сэргээлтийн стандартыг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх, нөхөн сэргээгдэлгүй орхигдсон газрыг гүйцээн нөхөн сэргээх арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, шаардлагатай хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргуулах замаар учирсан хохирлыг арилгуулах, уул уурхайн нөхөн сэргээлтийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилт, тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход оршино.



Хөтөлбөрийн зорилт:

Нэг. Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаа явуулахдаа байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгж, байгууллага, уурхайн эдэлбэр газар, талбайн тооллого явуулах, экологид учирсан хохирлыг тогтоон түүнийг нөхөн төлүүлэх;

Хоёр. Нөхөн сэргээх ажлын журам, эдэлбэр газрын экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлал, зааврыг шинэчлэн гаргах, ашигт малтмалын нэр төрөл, олборлож боловсруулах технологийн онцлогийг тусгасан газар, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн улсын стандартыг мөрдүүлэх;

Гурав. Ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааны байгаль орчны нөхөн сэргээлтийн гүйцэтгэлд орон нутгийн байгаль орчныг хамгаалах болон хяналтын байгууллагын зүгээс тавих хяналтыг сайжруулах;

Дөрөв. Хайгуул, ашиглалтын хаягдалгүй, байгаль орчинд халгүй технологийг нэвтрүүлэх, нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллагыг бий болгох;

Тав. Уул уурхайн нөхөн сэргээлтийн хяналтын механизмыг боловсронгуй болгох, мэдээлэл сурталчилгаа, сургалт, семинар зохион байгуулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- 1 дүгээр үе шат: 2007-2008 оныг дуустал;
- 2 дугаар үе шат: 2008-2010 оныг дуустал.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Нэгдүгээр зорилтын хүрээнд:

- ашигт малтмалын ордыг ашиглаж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага бүрийн уулын ажлын дэвсгэр зураг хийж, бүртгэх, эвдрэлд өртсөн талбайн хэмжээг тодорхойлох, эдэлбэр газарт нөхөн сэргээлт хийгээгүй талбайн хэмжээ, зээлхүүнийг тогтоох;

- эвдрсэн газрын тооллого хийж тусгай зөвшөөрөл эзэмшигч, хариуцагчийг тогтоох;

- хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр нөхөн төлүүлэх;

- хариуцагч нь тогтоогдоогүй газрын нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

- эвдрэлд орсон болон нөхөн сэргээлт хийсэн талбайн улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн сүлжээ бүрдүүлэх.

Хоёрдугаар зорилтын хүрээнд:

- ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын жил бүрийн байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээх төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний

хөтөлбөр, тайлан боловсруулах аргачлалыг шинэчлэн мөрдүүлэх;

- биологийн нөхөн сэргээлт хийх аргачлалыг газар зүй, экологийн онцлогийг харгалзан шинжлэх ухаан, технологийн үндэслэлтэйгээр шинэчлэн, хаалтын үеийн нөхөн сэргээлтийн төсөл боловсруулах аргачлал бий болгох, ашигт малтмалыг хайх, олборлох явцад үүссэн газрын эвдрэлийг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээг шинэчлэн мөрдүүлэх;

- ашигт малтмалын нэр төрөл, олборлож боловсруулах технологийн онцлогийг тусгасан газар, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн улсын стандартуудыг бий болгох;

- эдэлбэр газрын экологи-эдийн засгийн үнэлгээг хөрсний үржил шим, бүтэцтэй нь уялдуулан тогтоох, экологийн хохирлын төлбөр, нөхөн төлбөр, хураамжийг тооцох, хариуцуулах, төлүүлэх эрх зүйн механизмыг бий болгох;

- ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагааг хориглох, хязгаарлах газар, бүс нутгийг тогтоох, жагсаалтыг гаргах;

- уурхайг хэсэгчлэн буюу бүрэлд нь хаах үеийн нөхөн сэргээлтийн төсөл, томоохон төсөлд хаалтын нөхөн сэргээлтийн сан байгуулах механизмыг бүрдүүлэх.

Гуравдугаар зорилтын хүрээнд:

- ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг шилжүүлсэн тохиолдолд уурхайн эдэлбэр газрын байгалийн нөхөн сэргээлтийг бүрэн хийлгэж байх механизмыг бүрдүүлэх, төв, орон нутгийн хяналт, зохицуулалтыг сайжруулах;

- хайгуулын үйл ажиллагаа дууссаны дараа нөхөн сэргээлтийг заавал хийлгэх шаардлагыг орон нутгийн байгаль орчны албад, мэргэжлийн хяналтын газрууд хэрэгжүүлдэг болох;

- орон нутагт байгаль орчны албад, мэргэжлийн хяналтын газруудын ажлын уялдааг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх, жил бүр 2-оос доошгүй удаа нөхөн сэргээлтийн явцтай танилцан дүгнэлт гаргаж байх байнгын комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх.

Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

- нөхөн сэргээлтийн ажил эрхэлдэг мэргэжлийн алба, аж ахуйн нэгжийг байгуулж нөхөн сэргээлт хийгдээгүй болон дутуу хийгдсэн газрыг нөхөн сэргээх арга хэмжээ авч, зардлыг нөхөн төлүүлэх механизмыг бүрдүүлэх;

- алтны шороон орд болон бусад ашигт малтмалын ашиглалтын байгальд ээлтэй, дэвшилтэт технологийг сонгон мөрдүүлэх, энэ талаар гэрч байгаа тэргүүний арга туршлагыг нийтэд дэлгэрүүлэх;

- ашигт малтмалыг экспортд гаргахдаа хөрш орнуудтай байгуулсан авто тээврийн хэлэлцээрийн дагуу тээвэрлэлтийг зохион байгуулах, улс хоорондын тээвэрлэлтийн гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх.

- алт, хайлуур жонш, нүүрс зэрэг ашигт малтмалыг гар аргаар олборлосон тохиолдолд нөхөн сэргээлтийг заавал хийж байх эрх зүйн орчин бүрдүүлэх, хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох.

Тавдугаар зорилтын хүрээнд:

- нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон талбайд мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгэх үйл ажиллагааг жигдрүүлэх;

- нөхөн сэргээлт хийгээгүй орхисон аж ахуйн нэгж, байгууллага болон эвдэрч өөрчлөгдсөн талбайн талаар мэдээлэх, нөхөн сэргээлтийг стандартын дагуу мэргэжлийн түвшинд гүйцэтгэсэн аж ахуйн нэгж, байгууллагыг шалгаруулах, байгальд ээлтэй, хаягдалгүй технологиор ашигт малтмал ашиглахыг дэмжиж сурталчлах;

- нөхөн сэргээлтийн хөрөнгө барьцаалах, үүсмэл ордыг ашиглах, хайгуулын талбайг нөхөн сэргээхэд зөрчил гаргасан, нөхөн сэргээлтийн ажлыг орхигдуулсан, чанаргүй хийсэн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, тендер зарлан уг талбайг бусад аж ахуйн нэгжид шилжүүлэх, шинээр лиценз олгохгүй байх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

- төрийн захиргааны төв байгууллага, бүх шатны Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага хамтран хяналт тавьж ажиллах;

- ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад зориулан техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн талаар сургалт, семинар тогтмол зохион байгуулж байх;

- орон нутгийн удирдлага, хэсгийн төлөөлөгч, байгаль орчны мэргэжилтэн, байцаагч нарыг нөхөн сэргээлтийн дүрэм, журам, стандарт, нөхөн сэргээлтийн арга технологи, нөхөн сэргээлт хийгээгүйгээс гарах үр дагавар, экологийн хохирлын төлбөрийг тооцох, барагдуулах талаар сургалтад хамруулах.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

5.1. Удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтийг хангах, арга зүйн зөвлөгөө өгөх, салбар дундын зохицуулалт хийх, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн үйл ажиллагааны уялдааг хангах үндсэн дээр хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих үүргийг Улсын мэргэжлийн хяналтын газар, аймаг, нийслэл, орон нутгийн түвшинд тухайн аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хэрэгжүүлнэ.

5.2 Хөтөлбөр нь дараахь эх үүсвэрээс санхүүжнэ:

- а/улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;
- б/хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зардал;
- в/байгаль хамгаалах сангийн хөрөнгө;
- г/гадаад болон дотоодын хандивлагчдын тусламж, дэмжлэг, хандивын хөрөнгө;
- д/сум, дүүргийн Засаг даргын дэргэдэх төрийн сан.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжсэнээр гарах үр дүн

Хөтөлбөр хэрэгжсэнээр дараахь үр дүнд хүрнэ:

6.1. Хууль тогтоомж, журам, зөвлөмж, аргачлал, стандарт, норм, норматив бүрэн гарч эрх зүйн зохицуулалт бүрдсэн байна.

6.2. Нөхөн сэргээгдээгүй, хариуцах эзэнгүй газар байхгүй болж цаашид уул уурхайн үйлдвэрлэлийн нөхөн сэргээлтийн ажил дор дурдсанаар төлөвшсөн байна:

- уул уурхайн ашиглалтад өртсөн газрын зураглал, бүртгэл бий болж нөхөн сэргээгдээгүй эдэлбэр газарт техникийн, тэдгээрийн 80-аас доошгүй хувьд биологийн нөхөн сэргээлт хийсэн байна;

- нөхөн сэргээлтийн талаархи статистик мэдээллийг эвдэрсэн газрын талбайн хэмжээ, бодит эзэлхүүнээр жил бүр улсын нэгдсэн бүртгэлд хамруулж, нөхөн сэргээлтийн ажлыг иргэдийн хяналтад бүрэн шилжүүлсэн байна;

- ашигт малтмал олборлож байгаа бүх аж ахуйн нэгж, иргэд нөхөн сэргээлт хийх ажлыг шаардлагын дагуу, тогтоосон хугацаанд хийж хэвшсэн байна;

- нөхөн сэргээлт хийгээгүй, хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд ашигт малтмал цаашид олборлох эрхийг бүрмөсөн хориглох механизмыг бүрдүүлсэн байна;

- нөхөн сэргээлгүй орхисон эдэлбэр газрын талбайн хэмжээ, хариуцагчийг тогтоосон байна;

- хууль тогтоомж, дүрэм, журам ноцтой зөрчсөн этгээдэд хариуцлага тооцох механизмыг чангатгасан байна;

- нөхөн сэргээлтийн мэргэжлийн алба, аж ахуйн нэгж бий болгосон байна;

- орон нутгийн удирдлага, хэсгийн төлөөлөгч, байгаль орчны мэргэжилтэн, байцаагч нарыг нөхөн сэргээлтийн дүрэм, журам, стандарт, арга технологи, нөхөн сэргээлт хийгээгүйгээс гарах үр дагавар, экологийн хохирлын төлбөрийг тооцох, барагдуулах талаар бүрэн мэдээлэлтэй болсон байна.

Засгийн газрын 2006 оны 309 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

“АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БАЙГАЛЬ ОРЧИНД СӨРӨГ
НӨЛӨӨЛӨЛ, ХОХИРОЛ БАГАТАЙ ЯВУУЛАХ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцан гүйцэтгэх байгууллага
1.	Ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаа явуулж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээж үүргээ биелүүлсээгүй аж ахуйн нэгж, байгууллага, уурхайн эзэлбэр газар талбайн тооллого явуулах, экологид учирсан хохирлыг тогтоом, түүнийг нөхөн төлүүлэх	1. Ашигт малтмалын ордыг ашиглаж байгаа тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага бүрийн уулын ажлын дэвсгэр зураг хийж, бүртгэх, зөдрөлд өртсөн талбайн хэмжээг тодорхойлох, эзэлбэр газарт нөхөн сэргээлт хийгээгүй талбайн хэмжээ, эзлүүнийг тогтоох 2. Эздэрсэн газрын тооллого хийж тусгай зөвшөөрөл эзэмшигч, хариуцагчийг тогтоох 3. Өмнө нь ашиглагдаад нөхөн сэргээгдэлгүй орхигдсон төрийн өмчийн зарим уурхайнуудын нөхөн сэргээлтэд шаардлагатай зардлыг тооцоолж гаргах, эх үүсвэрийг шийдвэрлэх 4. Хохирлыг эзэмшигч, хариуцагчаар нь нөхөн төлүүлэх, хариуцагч нь тогтоогдоогүй газрын нөхөн сэргээлтийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх 5. Эздэрдэг орсон болон нөхөн сэргээлт хийсэн талбайн улсын хэмжээний бүртгэл, мэдээллийн сүлжээ бүрдүүлэх	2007 оны II улирал 2007-2010 он 2007 он 2007 он 2010 он	УМХГ, УХЯ, БОЯ УМХГ, УХЯ, БОЯ, УМБГ УХЯ, УМХГ, СЯ БОЯ, УМХГ УМХГ, УХЯ, БОЯ
2.	Нөхөн сэргээх ажлын журам, эзлбэр газрын экологи-эдийн засгийн үнэлгээний арга-члал, засварыг шинэчлэн гаргах, ашигт малтмалын нэр төрөл, олборлож боловсруулах төхөөрөлийн онцлогийг тусгасан газар, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн улсын стандартыг мөрдүүлэх	1. Ашигт малтмалын хайгуул, ашиглалт явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын жил бүрийн байгаль орчныг хамгаалах болон нөхөн сэргээх төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах арга-члалыг шинэчлэх 2. Биологийн нөхөн сэргээлт хийх арга-члалыг газар зүй, экологийн онцлогийг харгалзан шинжлэх ухаан, технологийн үндэслэлтэйгээр шинэчлэн, хаалтын үеийн нөхөн сэргээлтийн төсөл боловсруулах арга-члал бий болгох, ашигт малтмалыг хайх, олборлох явцад ууссан газрын эздэргэлийг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээг шинэчлэн мөрдүүлэх 3. Ашигт малтмалын нэр төрөл, олборлож, боловсруулах технологийн онцлогийг тусгасан газар, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн улсын стандартуудыг бий болгох	2007 оны I улирал 2007 оны I улираас 2008 он	БОЯ, УМХГ, ШУА БОЯ, УМХГ
			2007 оны I улирал	БОЯ, УХЯ, УМХГ, Стандартчилал хэмжил зүйн төв

	<p>4. Эдэлбэр газрын экологи-эдийн засгийн үнэлгээг хөрсний үржлийн шим, бүтэцтэй нь уялдуулан тогтоох, экологийн хохирлын төлбөр, нохон төлбөр, хураамжийг тооцох, харьцуулах, толуулах эрх зүйн механизмтай бий болгох</p> <p>5. Уурхайг хэсэглэн болон бүхэлд нь хаах үеийн нохон сэргээлтийн тооцоо, томоохон төсөлд хаалтын нохон сэргээлтийн сан байгуулах механизмтай бүрдүүлэх</p> <p>6. Орон нутгийн удирдлага, хэсгийн төлөөлөгч, байгаль орны мэргэжилтэн, бийцагч нарыг нохон сэргээлтийн дүрэм, журам, стандарт, нохон сэргээлтийн арга, Технологи, нохон сэргээлт хийж үйлдэх гарах үр дагавар, экологийн хохирлын төлбөрийг тооцох, барилдуулах талаар сургалтад хамруулах</p> <p>7. Ашигт малтмалыг хайх, олборлох үйл ажиллагааг хориглох, хязгаарлах газар, бүс нутгийг тогтоох, загварчлалыг гаргах</p> <p>8. Ашигт малтмалын орд газрууд хүртэлх утасан болон орон нутгийн чанартай авто замын засвар, ариалалтыг стандартын шаардлагын хэмжээнд байлгах асуудлыг тухайн ордыг ашиглаж байгаа аж ахуйн нэгжид харьцуулах тогтолцоог бүрдүүлэх</p>	<p>2007 оны I-II улирал</p> <p>2007 оноос</p> <p>2007 оноос</p> <p>2008-2010 он</p> <p>2008-2010 он</p>	<p>БОЯ, ХЗДХЯ, УХЯ, УМХГ</p> <p>БОЯ, УХЯ</p> <p>БОЯ, УМХГ, ЦЕГ</p> <p>БОЯ, ШУА, Аймгийн Засаг дарга нар</p> <p>ЭТЛЖЯ, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагууд</p> <p>УХЯ, УМХГ, Аймгийн Засаг дарга нар</p> <p>Аймгийн Засаг дарга нар, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагууд</p> <p>УМХГ, Аймгийн Засаг дарга нар</p> <p>УМХГ, БОЯ, Аймгийн Засаг дарга нар</p>
<p>3. Ашигт малтмал хайх, олборлох шилжүүлсэн тохиролдотд уурхайн эдэлбэр газрын байгалийн нохон орчны нохон сэргээлтийн орон нутгийн үйлдвэрт орон нутгийн байгаль орчны хамгаалагч болон хангалтын байгууллагын зүгээс тавих хангалтын зорилгыг сайжруулах</p>	<p>1. Ашигт малтмалыг хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг хийлгэх шийдвэрлэлтэй хамт хийлгэх газрын байгалийн нохон сэргээлтийн бүрэн хийлгэх байдлыг хангах зорилгыг бүрдүүлэх эвс ажилд төв, тусгай зорилгоор орон нутгийн хангалт, зохицуулалтыг сайжруулах</p> <p>2. Аймгуудад нохон сэргээлтийн дэд хөтөлбөр боловсруулах, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим томоохон компани, аж ахуйн нэгжүүдэд нохон сэргээлтийн хөтөлбөр хийлгэх</p> <p>3. Хайгуулын үйл ажиллагаа дууссаны дараа нохон сэргээлтийг заавал хийлгэх шаардлагыг орон нутгийн байгаль орчны албад, мэргэжлийн хангалтын газрууд хэрэгжүүлдэг болох</p> <p>4. Орон нутагт байгаль орчны албад, мэргэжлийн хангалтын газруудын ажлын үндэсний сайжруулах, чадварыг бэхжүүлэх, жил бүр 2-оос доошгүй удаа нохон сэргээлтийн явцтай танилцан дүнлэлт гаргаж байх байгалийн комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэх</p>	<p>2007 он</p> <p>2007-2010 он</p> <p>2007 оны I улирал</p> <p>2007-2010 он</p> <p>2007 оноос</p> <p>2007-2010 он</p>	<p>УХЯ, УМХГ, Аймгийн Засаг дарга нар</p> <p>Аймгийн Засаг дарга нар, холбогдох аж ахуйн нэгж, байгууллагууд</p> <p>УМХГ, Аймгийн Засаг дарга нар</p> <p>УМХГ, БОЯ, Аймгийн Засаг дарга нар</p> <p>БОЯ</p>
<p>4. Хайгуул, ашиглалтын хаалт, нөхцөл байдал, хайгуул, ашиглалтын хаалт, нөхцөл байдал, технологийг нэвтрүүлэх, нохон сэргээлтийн мэргэжлийн байгууллагыг бий болгох</p>	<p>1. Нохон сэргээлтийн ажил эрхэлдэг мэргэжлийн алба, аж ахуйн нөхцөл, байгаль орчныг хайгуул, ашиглалтын хаалт, нөхцөл байдал, технологийг нэвтрүүлэх, нохон сэргээлтийн мэргэжлийн байгууллагыг бий болгох</p>	<p>2007-2010 он</p>	<p>БОЯ</p>

	2007-2010 он	УХЯ, УМХГ
2 Алтны шороон орд болон бусад ашигт малтмалын ашиглалтын байгальд эзлэх, дэвшилтэт технологийг сонгон мөрдүүлэх, энэ талаар гарч байгаа тэрүүний арга туршлагыг нийтэд дэлгэрүүлэх 3 Ашигт малтмалыг экспортод гаргахдаа жорш оруулдаг байгуулсан ангу тээврийн хангамжийн дагуу тээвэрлэлтийг зохион байгуулах, улс хоорондын тээвэрлэлтийн гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх 4 Алт, хайгуур юмши, нүүрс зэрэг ашигт малтмалыг гар аргаар олборлосон тохиолдолд ноён сэргээлийг заавал хийж байх эрх зүйн орчин бүрдүүлэх, хууль бус үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох	2007-2010 он 2007-2010 он 2008-2009 он 2008-2010 он	УХЯ, УМХГ ЗТАКЯ, БОЯ БОЯ, УХЯ, Аймгийн Засаг дарга нар БОЯ, УМХГ
5. Уул уурхайн ноён сэргээлийн хангамж механизмыг боловсруулж, мэдээлэл сурталчилгаа, сургалт, семинар зохион байгуулах, олон улсын хамтын ажиллагааг өрсөжүүлэх	2008-2010 он	БОЯ, УМХГ
6. Ноён сэргээлийн талаар уурвал бүр мэдээ авах, улсын статистик мэдээнд хамруулах	2007-2010 он 2007-2010 он 2007-2010 он 2007-2010 он 2007 оны 1 улирлаас эхлэн	БОЯ, УХЯ, УМХГ УМХГ, Аймгийн Засаг дарга нар, БОЯ БОЯ, УМХГ, Аймгийн Засаг дарга нар БОЯ, УМХГ, Аймгийн Засаг дарга нар БОЯ, УМХГ БОЯ, УМХГ БОЯ, УХЯ, Ундэсний статистикын газар



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 409 төгрөг 15 мөнгө буюу сард 69000 (жаран есөн мянган) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2006 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээг 1 дүгээр, Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Улсын дээд шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Үндсэн хуулийн цэц, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Сонгуулийн ерөнхий хороо болон тэдгээртэй адилгах төрийн байгууллагын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээг 2 дугаар, төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээг 3 дугаар, төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод жишгийг 4 дүгээр хэвсрэлт ёсоор

Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай

тус тус шинэчлэн баталж, 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2006 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 147 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД**

Засгийн газрын 2007 оны 13 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(саяд төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл												
	T3-1	T3-2	T3-3	T3-4	T3-5	T3-6	T3-7	T3-8	T3-9	T3-10	T3-11	T3-12	T3-13
1	88470	94705	102695	108931	115166	122766	128222	135238	142643	150048	158038	164858	172458
2	94705	102305	111269	118284	125299	132510	138551	145176	153556	159986	176744	183175	187657
3	100942	109710	119844	127834	135238	142643	148684	154920	164468	169925	195647	199154	202856
4	107372	117310	128418	136952	145372	152581	158816	164663	175186	179668	-	-	-
5	113802	124910	136992	146150	155504	162324	168755	174407	185904	189606	-	-	-

 Засгийн газрын 2007 оны 13 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛОГЧ, ЗАСГИЙН ГАЗАР, УЛСЫН ДЭЭД ШҮҮХ, УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР, ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦ, ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДСЭНИЙ КОМИСС, ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ҮНДСЭНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ, СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО БОЛОН ТЭДГЭЭРТЭИ АДИЛТГАХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(саяд төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шатлал	Албан тушаалын зэрэглэл										
	AA-11	AA-10	AA-9	AA-8	AA-7	AA-6	/ A-5	AA-4	AA-3	AA-2	AA-1
1	109321	115166	122766	128028	135238	142843	149854	155504	163688	171678	180058
2	119064	125299	132510	137966	145176	152971	159402	164663	179863	187267	195257
3	128612	135238	142643	148294	154724	163104	168755	174017	196037	202856	210457
4	137966	145372	152776	158428	164468	173432	178499	183371	-	-	-
5	147709	155504	162324	168560	174407	183760	188047	192529	-	-	-

Засгийн газрын 2007 оны 13 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН СҮЛЖЭЭ

(саяд төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шагнал	Албан тушаалын зэрэглэл																	
	ТТ-1	ТТ-2	ТТ-3	ТТ-4	ТТ-5	ТТ-6	ТТ-7	ТТ-8	ТТ-9	ТТ-10	ТТ-11	ТТ-12	ТТ-13	ТТ-14	ТТ-15	ТТ-16	ТТ-17	ТТ-18
1	82039	88470	94705	100942	103669	105228	111464	115166	122962	123740	125885	128028	135238	142643	147515	155309	163688	172458
2	84664	94705	102305	109516	112439	114776	121207	125299	132314	133679	136018	138161	145176	153556	158008	174407	181616	187657
3	95095	100942	106710	118090	121207	124530	131146	135238	141668	143423	145956	148294	154620	164468	168308	193894	199544	202856
4	101526	107177	117310	126469	130171	134069	140694	145372	151022	153166	155864	158622	164858	175186	178693			
5	108151	113802	123410	134849	139135	143617	150438	155504	160181	162910	165832	168560	174407	185904	189022			

Засгийн газрын 2007 оны 13 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

(саяд төгрөгөөр)

Цалингийн сүлжээний шагнал	Албан тушаалын зэрэглэл													
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3	ТҮ-4	ТҮ-5	ТҮ-6	ТҮ-7	ТҮ-8	ТҮ-9	ТҮ-10	ТҮ-11	ТҮ-12	ТҮ-13	ТҮ-14
1	77947	78726	80675	83014	84572	91588	98408	105424	112243	121013	129587	141864	155699	169535
2	78726	80675	83014	84182	90223	97628	104449	111464	118284	127248	142643	153946	166027	183175
3	80675	83014	85741	89054	95875	103669	110684	117505	124326	133289	155699	165832	176354	196621
4	85741	89664	91003	93926	101526	109710	116141	123546	130561	139330				
5	91393	94316	95875	98408	107177	115751	121403	129587	136602	145176				



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28.6 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож, 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй:

Дүүргийн Засаг дарга 147888-174408

Сумын Засаг дарга 137592-163644

Хорооны Засаг дарга 111384-132288

Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай

Багийн Засаг дарга 96720-116532

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2006 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 51750 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 34500 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн тооцон олгох арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал,

Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

хөдөлмөрийн сайд Л.Одончимэд, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 247 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Л.ОДОНЧИМЭД**

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 47 дугаарт нийтлэгдсэн Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуулийн нэгдүгээр хэсрэлтээр баталсан "Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын XXVIII.1.12-ын "Зам засвар, гэрэлтүүлэг, Горькийн гудамжны зам засвар /Улаанбаатар, БГД/" гэснийг "Зам засвар, гэрэлтүүлэг, Горькийн гудамжны зам засвар /Улаанбаатар, БГД, 5, 6, 7, 8-р хороог" гэж залруулан уншина уу.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэл хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265058
Индекс 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 3.5